



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/45/НА-СБА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт хот 2022 он	Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.САРУУЛТУЯА ТАНАА

᠒᠐21.12.25 № ᠖᠐
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,883,778.00</u>	<u>92,811,788.00</u>
33	АВЛАГА	9,076,468.00	2,820,000.00
335	Бусад авлага	9,076,468.00	2,820,000.00
3351	Байгууллагаас авах авлага	9,076,468.00	2,820,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,807,310.00	89,991,788.00
351	Түүхий эд материал	00.00	3,402,520.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	3,402,520.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	320,000.00
354	Хангамжийн материал	9,615,310.00	67,469,268.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	795,408.00
35420	Аж ахуйн материал	80,000.00	80,000.00
35470	Бусад хангамжийн материал	9,535,310.00	66,593,860.00
35600	Мал амьтад	5,192,000.00	18,800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,040,109,585.63</u>	<u>1,009,500,583.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,040,109,585.63	1,009,500,583.42
392	Биет хөрөнгө	1,025,781,585.63	995,172,583.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	603,080,520.10	608,578,520.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-66,434,079.64	-99,663,601.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	236,640,550.00	222,440,550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-188,575,439.76	-190,410,216.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	136,836,634.00	176,238,769.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,555,812.31	-81,552,049.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,123,934.00	40,669,344.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,644,185.67	-30,650,476.63
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,563,664.00	00.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	972,160,312.00	936,286,125.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-612,414,511.09	-586,764,379.95
393	Биет бус хөрөнгө	14,328,000.00	14,328,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,328,000.00	14,328,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,063,993,363.63</u>	<u>1,102,312,371.42</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,144,625.00</u>	<u>3,321,857.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,144,625.00	3,321,857.00
413	Өглөг	1,144,625.00	3,321,857.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	34,625.00	3,321,857.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,110,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,062,848,738.63</u>	<u>1,098,990,514.42</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,062,848,738.63	1,098,990,514.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	483,719,481.17	483,719,481.17
51101	Өмч: - төрийн	483,719,481.17	483,719,481.17
512	Хуримтлагдсан үр дүн	274,131,850.16	310,273,625.95
51210	Өмнөх үеийн үр дүн	274,131,850.16	274,131,850.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	36,141,775.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	304,997,407.30	304,997,407.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,063,993,363.63</u>	<u>1,102,312,371.42</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	711,461,528.00	687,257,266.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	209,184,280.00	100,793,013.00
120	Нийтлэг татварын бус орлого	209,184,280.00	100,793,013.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	209,184,280.00	100,793,013.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	209,184,280.00	100,793,013.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	502,277,248.00	586,464,253.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,723,248.00	6,135,953.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,600,412.00	50,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,700,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,152,836.00	5,100,953.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,270,000.00	985,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,554,000.00	580,328,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,554,000.00	580,328,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	584,746,585.85	637,771,960.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	554,746,585.85	637,771,960.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,860,818.85	583,039,080.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,887,365.00	247,142,943.00
210101	Үндсэн цалин	211,642,070.00	149,367,930.00
210102	Нэмэгдэл	00.00	48,756,199.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,461,000.00
210104	Урамшуулал	00.00	8,900,166.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,245,295.00	26,657,648.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,987,205.00	32,102,504.00
210201	Тэтгэврийн даатгал	19,216,453.00	22,471,934.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,350.00	2,450,687.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,801,078.00	1,824,452.84
210204	Ажилгүйдлийн даатгал	423,577.00	610,205.67
210205	Эрүүл мэндийн даатгал	4,294,747.00	4,745,223.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,129,272.00	30,863,742.64
210301	Гэрэл, цахилгаан	6,071,872.00	10,806,342.64
210302	Түлш, халаалт	19,542,600.00	19,542,600.00
210303	Цэвэр, бохир ус	514,800.00	514,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,538,100.60	15,634,585.00
210401	Бичиг хэрэг	3,209,200.00	3,480,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,303,511.00	8,895,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,208,860.00	2,259,365.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	608,600.00	1,000,000.00
210408	Бараа материал акталсны зардал	9,207,929.60	00.00
2105	Нормативт зардал	5,371,400.00	450,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,591,400.00	50,000.00
210502	Хоол, хүнс	320,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	460,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,528,000.00	14,711,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,581,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,947,000.00	14,711,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,257,725.00	2,330,000.00

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	1,257,725.00	2,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,311,648.00	24,391,259.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,529,948.00	23,648,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	371,700.00	371,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	239,059.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	212,850,103.25	215,413,046.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,656,218.00	101,487,701.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,611,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,193,885.25	111,314,345.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,885,767.00	54,732,880.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,232,780.00	14,467,642.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,232,780.00	5,953,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	7,013,242.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,501,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,652,987.00	40,265,238.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,652,987.00	40,265,238.36
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,000,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	126,714,942.15	49,485,305.36
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	66,343,530.56	13,343,529.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	66,343,530.56	13,343,529.57
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-66,343,530.56	-13,343,529.57
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	60,371,411.59	36,141,775.79

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	469,391,481.17	132,987,333.22	705,955,342.89	00.00	1,308,334,157.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,000,000.00	00.00	5,000,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,391,481.17	132,987,333.22	710,955,342.89	00.00	1,313,334,157.28
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	80,188,826.30	00.00	80,188,826.30
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	274,131,850.16	00.00	1,062,848,738.63
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	274,131,850.16	00.00	1,062,848,738.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	274,131,850.16	00.00	1,062,848,738.63
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	36,141,775.79	00.00	36,141,775.79
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	310,273,625.95	00.00	1,098,990,514.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	502,277,248.00	595,336,861.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	502,277,248.00	595,336,861.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,723,248.00	15,008,561.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,600,412.00	50,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,700,000.00	8,872,608.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,152,836.00	5,100,953.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,270,000.00	985,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,554,000.00	580,328,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,554,000.00	580,328,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	435,233,048.00	546,774,601.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,233,048.00	546,774,601.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	409,474,673.00	489,221,720.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,912,557.00	244,021,288.00
210101	Үндсэн цалин	211,667,262.00	146,246,275.00
210102	Нэмэгдэл	00.00	48,756,199.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,461,000.00
210104	Урамшуулал	00.00	8,900,166.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,245,295.00	26,657,648.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,978,682.00	31,733,067.00
210201	Тэтгэврийн даатгал	19,207,930.00	22,102,497.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,350.00	2,450,687.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,801,078.00	1,824,452.84
210204	Ажилгүйдлийн даатгал	423,577.00	610,205.67
210205	Эрүүл мэндийн даатгал	4,294,747.00	4,745,223.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,129,272.00	30,863,742.64
210301	Гэрэл, цахилгаан	6,071,872.00	10,806,342.64
210302	Түлш, халаалт	19,542,600.00	19,542,600.00
210303	Цэвэр, бохир ус	514,800.00	514,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,610,171.00	15,634,585.00
210401	Бичиг хэрэг	2,489,200.00	3,480,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,303,511.00	8,895,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,208,860.00	2,259,365.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	608,600.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	5,371,400.00	450,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,591,400.00	50,000.00
210502	Хоол, хүнс	320,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	460,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,528,000.00	18,436,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,581,000.00	75,050.00
210604	Урсгал засвар	1,947,000.00	18,361,000.00
2107	Томилолт, зочны зардал	147,725.00	3,440,000.00
210702	Дотоод албан томилолт	147,725.00	3,440,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,140,648.00	17,448,759.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,358,948.00	16,706,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	371,700.00	371,700.00

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	239,059.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,656,218.00	127,194,229.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,656,218.00	124,583,229.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,611,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,758,375.00	57,552,880.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,232,780.00	14,467,642.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,232,780.00	5,953,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	7,013,242.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,501,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,525,595.00	43,085,238.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,525,595.00	43,085,238.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	67,044,200.00	48,562,260.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	67,044,200.00	48,562,260.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	67,044,200.00	48,562,260.00
2200	Дотоод эх үүсвэрээр	67,044,200.00	48,562,260.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,044,200.00	48,562,260.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-67,044,200.00	-48,562,260.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	679,124,900.00	540,063,061.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	679,124,900.00	540,063,061.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	638,265,600.00	526,995,419.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,530,600.00	243,385,688.00
210101	Үндсэн цалин	148,568,200.00	145,995,675.00
210102	Нэмэгдэл	49,313,200.00	48,756,199.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,480,000.00	13,461,000.00
210104	Урамшуулал	8,639,600.00	8,515,166.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,529,600.00	26,657,648.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,135,000.00	31,701,742.00
210201	Тэтгэврийн даатгал	21,644,700.00	22,071,172.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,622,600.00	2,450,687.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,098,100.00	1,824,452.84
210204	Ажилгүйдлийн даатгал	524,500.00	610,205.67
210205	Эрүүл мэндийн даатгал	5,245,100.00	4,745,223.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,876,100.00	30,863,742.64
210301	Гэрэл, цахилгаан	10,808,100.00	10,806,342.64
210302	Түлш, халаалт	19,548,000.00	19,542,600.00
210303	Цэвэр, бохир ус	520,000.00	514,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,085,500.00	14,082,949.00
210401	Бичиг хэрэг	2,850,900.00	2,850,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,004,600.00	8,003,384.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,230,000.00	2,229,365.00

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	400,000.00	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,961,300.00	40,301,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,901,000.00	24,190,310.00
210602	Тавилга	17,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	56,060,300.00	16,111,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,318,400.00	3,300,000.00
210702	Дотоод албан томилолт	3,318,400.00	3,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,087,700.00	17,048,759.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,309,400.00	16,306,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	371,700.00	371,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	263,600.00	239,059.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	186871000.00	145911229.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	186,070,000.00	145,110,229.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	801,000.00	801,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40859300.00	13067642.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,859,300.00	13,067,642.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,953,400.00	5,953,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,313,300.00	6,313,242.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,791,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	801,000.00	801,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	679,124,900.00	540,063,061.64
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	679,124,900.00	540,063,061.64
131001	Улсын төсвөөс санхүүжих	679,124,900.00	540,063,061.64
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	22.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	06.00	06.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	10.00	10.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	06.00	06.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,188,561.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,188,561.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,788,561.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	635,600.00
210101	Үндсэн цалин	250,600.00
210102	Нэмэгдэл	
210104	Урамшуулал	385,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,325.00
210201	Тэтгэврийн даатгал	32,325.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,551,636.00
210401	Бичиг хэрэг	630,000.00
210402	Тээвэр, шатахуун	891,636.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2105	Нормативт зардал	50,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,720,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	470,000.00
210604	Урсгал засвар	2,250,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5260000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,810,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1400000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12188561.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,188,561.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,052,608.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,100,953.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	985,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар нь “Төрийн үйлчилгээг иргэн бүрт ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, тэдэнд үр бүтээлтэй хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэн өгч, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялаг бүтээгч, эрх чөлөөтэй, дундаж орлоготой иргэд зонхилсон нийгмийн хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх зорилт дэвшүүлэн үйл ажиллагаандаа 540.6 сая төгрөгийг зарцуулан ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Түмэнцогт сумын Засаг даргын тамгын газар төвд тайлант хугацаанд Санхүүгийн хяналт аудитын албаны төлөвлөгөөт шалгалтыг 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдэж зөрчил илрээгүй бөгөөд малын үнийг зах зээлийн үнээр данс бүртгэлд тусгах зөвлөмж өгчээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 456.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.8 сая, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23.8	92.8	68.9
Авлага	9.0	2.8	-6.2
Бусад авлага	9.0	2.8	-6.2
Бараа материал	14.8	89.9	75.1
Үндсэн хөрөнгө	1,040.1	1,009.5	-30.6
Нийт хөрөнгө	1,144.6	3,321.8	2,321.8
Өр төлбөр	1.1	3.3	2,321.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,062.8	1,098.9	36.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,063.9	1,102.3	38.3

Бараа материалын дансны үлдэгдэл 89.9 сая төгрөг болж 75.1 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,009.5 сая төгрөг 30.0 сая төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын 2021 оны 71 дугаар тогтоолоор бусад хөрөнгө 33.1 сая, ОНХС-аар тоног төхөөрөмж 12.3 сая, нийт 45.4 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга 48.6 сая нийт 94.0 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, аймгийн ИТХ-ын 2021 оны 77 дугаар тогтоолоор 14.2 сая, аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 618 дугаар албан бичгээр 87.4 сая төгрөгийг данснаас хасаж, 115.2 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 2.8 сая төгрөг болж өссөн буурсан нь “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн авлага.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,098.9 сая төгрөг болж 36.1 сая төгрөгөөр өссөн байна.

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 24.2 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан нь орон нутгийн санхүүжилт 145.7 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 81.1 сая, нийт 226.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, бөгөөд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 108.4 сая төгрөгөөр буурсан нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 53.0 сая төгрөг буюу 0.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөрийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 588.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 588.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 679.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжих 540.0 сая, урсгал үйл ажиллагаанд 497.0 сая төгрөгийг зарцуулж, 43.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 5.1 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6.0 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 1.0 сая нийт 12.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамжийн бараа материал 1.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 4.0 сая, бараа үйлчилгээний бусад зардал 5.2 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 1.4 сая, нийт 12.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарчээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд засаг даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулж 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.3 хувийн биелэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 29, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26 мэдээллийг мөн хоцроосон, нийт 55 мэдээлэл хоцроож, шилэн дансны цахим хуудсанд байршуулжээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмжийг биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	0.1	1	0.1	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн	2	0.1	1	0.1	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 33.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 асуудалд зөвлөмж өгсөн бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдэл 111.3 сая төгрөгийг залруулав.

4.1 ТӨЛБӨРИЙН АКТ

4.1.1 Тамгын газрын даргад үр дүнгийн урамшуулал 0.3 сая төгрөгийг хууль эрх зүйн шийдвэргүй олгожээ.

Энэ нь МУЗЗНДНТУ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 /Энэ хуулийн 26.2-т зааснаар нэр дэвшүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргыг Монгол Улсын Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг сум, дүүргийн Засаг дарга тус тус 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд нөхөн томилогдсон Засаг даргад энэ хугацаа хамаарахгүй/, 26.8 /Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тухайн Хурлын болон дээд шатны Засаг даргын өмнө, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн Хурлын болон Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцна/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/ 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.5/.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна/ дахь заалт, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

4.2 Албан шаардлага

4.2.1 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахлын нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг баталсан. Уг тогтоолыг баримтлалгүй цалингийн зардлаас төсөвт зохицуулалт хийлгэж тоног төхөөрөмж бэлтгэсэн, засаг даргын нөөц сангаас гэр худалдан авсан, спортын тэмцээн уралдааны зардал зэрэгт нийт 31.8 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 6.4.2 /төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, 16 дугаар зүйлийн 16.5.5 ./батлагдсан төсвийг

зориулалтын дагуу зарцуулах/ заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

4.2.2 Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага 392.6 сая төгрөгийн 24 мэдээлэл болон сар бүр мэдээлэх 29 мэдээлэл, нийт 55 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хоцроосон алдаа зөрчил илэрлээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

4.2.3 Засаг даргын томилдог багийн дарга, санхүү төрийн сангийн албаны дарга нарт үр дүнгийн урамшуулал 1,459,715 төгрөгийг тамгын газрын даргын шийдвэрээр олгосон зөрчил илэрлээ. Энэ нь МУЗЗНДНТУ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3./Энэ хуулийн 26.2-т зааснаар нэр дэвшүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргыг Монгол Улсын Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг сум, дүүргийн Засаг дарга тус тус 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд нөхөн томилогдсон Засаг даргад энэ хугацаа хамаарахгүй/, 26.8 /Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга тухайн Хурлын болон дээд шатны Засаг даргын өмнө, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн Хурлын болон Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцна/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/ 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.3.1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

4.3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 106 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

4.3.1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түмэнцогт сумын Засаг даргын тамгын газар	4	33.5	-	-	1	0.3	3	33.2	1	-

/сая төгрөгөөр/

